НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2023 оны 06 сарын 26 өдөр Дугаар А/720 Улаанбаатар хот

Захирамжийн хавсралтад
өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.1.2 дахь заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 115, 2023 оны 52 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.“Эрх шилжүүлэх тухай” Нийслэлийн Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн А/1633 дугаар захирамжийн хавсралтаар батлагдсан “Нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2022 онд Сонгинохайрхан дүүрэгт хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ жагсаалт”-д заасны дагуу “9, 10” дахь заалт нэмсүгэй.

2.Мөн жагсаалтын “1” дэх заалтыг хүчингүй болгосугай.

3.Захирамжийн хавсралтад заасан төсөл, арга хэмжээг гүйцэтгэлээр нь холбогдох хууль, журмын дагуу хянан баталгаажуулж, санхүүжилтийн эрх нээхийг Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтэст, нээсэн эрхийг үндэслэн батлагдсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (Н.Наранбаатар)-т, “9” дэх заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг “Нийслэлийн Хөрөнгө оруулалтын газар” ОНӨААТҮГ (Б.Мөнхбат)-т, “10” дахь заалтад тусгагдсан төсөл, арга хэмжээнд захиалагчийн хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Цахим хөгжил, мэдээлэл технологийн газар (О.Чинзориг)-т, хөрөнгө оруулалтын үр дүнд бий болсон хөрөнгийг нийслэлийн өмчид бүртгэн авч, эзэмшил, ашиглалтад нь хяналт тавьж ажиллахыг Нийслэлийн Өмчийн харилцааны газар (Ч.Сайханбаяр)-т тус тус даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР
ХОТЫН ЗАХИРАГЧ Д.СУМЪЯАБАЗАР

1110203101

Нийслэлийн Засаг даргын 2023 оны
06 дугаар сарын 26-ны өдрийн
А/720 дугаар захирамжийн
хавсралт

НИЙСЛЭЛИЙН ОРОН НУТГИЙН ХӨГЖЛИЙН САНГИЙН ХӨРӨНГӨӨР 2022-2023 ОН ДАМЖИН СОНГИНОХАЙРХАН ДҮҮРЭГТ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ЖАГСААЛТ

(сая төг)

д/д	Төсөл, арга хэмжээний нэр, хүчин чадал, байршил	Хугацаа		Төсөвт өртөг	2023 онд санхүүжих дүн
		Эхлэх	Дуусах		
9	Автобусны буудлын тохижилт (СХД, 3, 41 дүгээр хороо)	2022	2023	69.0	69.0
10	263 дугаар цэцэрлэгийн камержуулалт (СХД, 36 дугаар хороо)	2022	2023	11.0	11.0